


Аюулгүй үйл ажиллагааны нэг чухал хэсэг бол хүн юм.

2023 оны 02 сар



Зураг 1: Танкны түвшин хянах сонголтууд

CSB report 2010.02.1.PR (Зураг 13)

Нэгэн компани шатамхай шингэн хадгалах танкны талбайд эрсдэл болон аюулын үнэлгээ хийж байсан. Аюулгүйн системийг шалгах үед хамгийн дээд хязгаар хэтэрсэн тохиолдолд анхааруулах дохиоллын идэвхжих тавилын цэгтэй холбоотой асуулт гарсан. Холбогдох инженер тавилын цэг нь танкны өндрийн 99% дээр байдаг хэмээн (сулхан) хариулсан. Хэрэв энэ нь үнэн бол шингэн дүүргэх үед хамгийн дээд хязгаарын дохиолол операторт анхааруулахаас өмнө танк халих буюу урсгалыг зогсоох арга хэмжээ авч амжихгүй байх боломжтой юм. Тухайн баг үүнийг маш ноцтой доголдол хэмээн дүгнэж, үйлдвэрлэлийн процессын аюулын үнэлгээний ажлыг зогсоосон.

Засварын багийн ажилчид хэд хэдэн танкны хамгийн дээд хязгаарын дохиоллын тохиргоог шалгахад бүгд 99% дээр идэвхжээр тохируулагдсан байсан. Түвшнийг зөв тохируулах шинэ багажууд суурилуулах хүртэл танкуудыг аюулгүй дүүргэхийн тулд түр журам мөрдүүлсэн.

Тус үйлдвэрт танк хальж асгараагүйн цорын ганц шалтгаан нь нэг ширхэг захиргааны хяналтын арга байсан. Химийн бодис захиалсан ажилтан өөрөө танкны түвшин болон хэрэглээг хянаж, зөвхөн танкны түвшингийн 85% хүртэл дүүргэх хэмжээний бодис дахин захиалдаг байсан аж. Энэхүү дан ганц хамгаалалт нь тухайн хувь хүний үйлдлээс бүхэлдээ хамаарч байсан хэдий ч бодис захиалахтай холбоотой шаардлагуудыг тодорхой журамд тусгаж баримтжуулаагүй байсан.

Та мэдэх үү?

- Хяналтын арга хэмжээнүүдийн шатлалын ангилалд зөв бүтэцтэй инженерийн хамгаалалтын системийг (дээд хязгаар хэтрэх үед унтрах гэх мэт) захиргааны хяналтын аргаас (дээд хязгаар хэтрэх буюу дохиолол идэвхжих үед оператор хавхлагыг гараараа хаах гэх мэт) илүү найдвартай (хүчтэй) хэмээн тооцдог.
- Инженерийн хяналтын системийн бүтэц, угсралт болон ашиглалтыг (үзлэг шалгалт, тохиргоо, тест) зохих шаардлагын дагуу зөв гүйцэтгэх ёстой.
- Тухайн систем нь захиргааны хяналтад хамаарах эсэхийг доорх шинжүүдээр тодорхойлж болно:
 - Зохих арга хэмжээнүүд болон тэдгээрийн дэс дарааллыг журамд тусган баримтжуулах;
 - Операторуудад тухайн журмыг хэрхэн аюулгүй мөрдөх талаар сургалт олгох;
 - Операторууд тухайн ажлыг журамд тусгасны дагуу гүйцэтгэх боломжтой эсэхийг бататгах;
- Инженерийн болон захиргааны ангилалд багтах эсэхээс үл хамааран бүх хяналтын арга нь аливаа таагүй нөхцөл үүсэхээс нэн даруй сэргийлэх эсвэл үүссэн тохиолдолд холбогдох үр дагаврыг аль болох бууруулахын тулд зохих хариу арга хэмжээг авах боломжтой байх ёстой.

Та юу хийж болох вэ?

- Үйлдвэрлэлийн аль нэг процесс дээр ажиллахдаа аюулгүйн системүүд болон тэдгээрийн ажиллагааны талаар сайн мэдэж авах хэрэгтэй. Ингэснээр ямар нэгэн доголдол үүсвэл зөв хариу арга хэмжээ авах боломжтой.
- Үзлэг шалгалт эсвэл үйл ажиллагааны явцад аль нэг аюулгүйн системийн ажиллагаа хэвийн бус байгааг олж илрүүлбэл нэн даруй мэдээл. Энэ нь ямар үр дагаварт хүргэж болохыг тухайн үед мэдэхгүй байж болно.
- Үйлдвэрлэлийн Процессын Аюулын Дүн Шинжилгээ гэх мэт аюулыг үнэлэх ажлуудад оролцохдоо аюулгүйн системд ажиглагдсан аливаа доголдлын талаар асууж тодруулахаас бүү зайлсхий.

Хяналтын систем доголдолгүй, найдвартай, шуурхай байх ёстой!